

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2021/01/06 **Дуусах хугацаа:** 2021/02/06

Ажил эхлэх хугацаа: 2021/02 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын Засгийн газар болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Бид дараах ажлын байрандаа ажилтан сонгон шалгаруулж авна.

ОЮУТНЫ БАЙРНЫ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Дотуур байранд амьдарч буй оюутнуудтай ганцаарчлан болон бүлгээр уулзалт хийж, санал хүсэлтийг нь сонсож ажиллах;
- Дотуур байранд гарч болох асуудлууд болох өрөөний хүүхэдтэйгээ зөрчилдөх, хувийн, сэтгэл зүйн болон бусад асуудлуудад анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх;
- Дотуур байрны үйл ажиллагааг хэвийн, эмх цэгцтэй байлгахын тулд дүрэм, журмыг мөрдүүлэх. Шинэ оюутнуудад дотуур байрны журмыг танилцуулж, тайлбарлан, журам зөрчсөнөөс үүдэн гарах үр дагавраас сэрэмжлүүлэх;
- Шаардлагатай үед эмнэлгийн яаралтай анхны тусламж үзүүлэх;
- Дотуур байрны аюулгүй байдлыг хангахын тулд байраар тогтмол явж үзэх;
- Дотуур байрны өдөр тутмын үйл ажиллагаанд хамаарах өрөөний түлхүүр тараах, буцааж авах, эвдрэлийн үнэлгээг гаргах, төлбөр тооцоо, засвар хийлгэх хүсэлт гаргах, дотуур байрны хаалгыг түгжих, онгойлгох зэрэг үүргийг гүйцэтгэх;
- Өрөө тасалгаанд үзлэг хийж, цэвэрлэгээнд хяналт тавих, засвар үйлчилгээг хийлгэх, өрөө солих хүсэлт хүлээж авах зэргээр дотуур байрны зохион байгуулалтын ажлыг хариуцах.

Тавигдах шаардлага:

- Сэтгэл судлал, нийгмийн ажилтан, боловсрол судлал мэргэжлийн аль нэгээр бакалаврын зэрэгтэй байх;
- Коллеж эсвэл их, дээд сургуульд 3 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх (Багш, зохион байгуулагчаар ажиллаж байсан бол давуу тал болно.)
- Харилцааны өндөр соёлтой, бичгийн болон ярианы өндөр чадвартай байх;
- Бие даан ажиллах чадвартай байх;
- Оюутнуудад чиглэсэн үйлчилгээг үзүүлж чаддаг байх;
- Microsoft Office (Word, Excel and Power Point) програмуудыг чөлөөтэй ашигладаг байх;
- Монгол болон Англи хэлний B1 түвшний ярианы болон бичгийн чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа

Холбоо барих:

Та тус ажлын байранд тавигдах шаардлагыг хангаж байгаа бол бичиг баримтаа зарласан хугацаанд багтаан recruitment@gmit.edu.mn хаягаар цахим хэлбэрээр бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Мөн бидэнтэй (+976 7023-2090) тоот дугаараар холбогдох боломжтой.

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.



**БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**



giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

DAAD

Deutscher Akademischer Austausch Dienst
German Academic Exchange Service